

**Америкийн Нэгдсэн Улсын
Үндэсний Архивд хадгалагдаж буй
Монгол улстай холбоо бүхий
зарим баримтууд**

(И. Бямбабаатар нь эдгаар баримтын хуулбарыг 2003 онд Монгол улсын үндэсний архивт өгч, монгол хэлээр каталогжуулсан болно)

Д/д	Sub No Бүр№	From Хаанаас	Date Өдөр	To Хаана,Хэнд	Purport Товч агуулга
1	893/1146a	Вашингтон, Төр-ийн Яам	1912- 03-02	Бээжин, /Виллям/	-АНУ-н Сенат, Төлөөлөгчдийн танхимаас Хятадын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, баяр хүргэсэн шийдвэр /1912-02-28-нд гарсан 368-р тогтоол/
2	893/1159	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912- 02-02	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Хайлаар дахь Лу Пян Фугийн хэлцэл. -Монголчууд Хайлаарыг эзэлсний дараа Манжуур өртөөний дэргэдэх Лу Пян Фу дахь Хятадын эрх баригчдыг Монголчууд даруй явахыг шаардсан тухай. Цэцхараас Тао Тай Цин ирж, Оросуудтай уулзсан тухай
3	893/1160	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912- 02-06	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Монгол, Оросууд Лу Пян Фу руу дайрсан тухай. -Цэцхарын захирагчаас Харбинд сууж буй Тао Тайд Лу Пян Фу болон Манжуур өртөөний байдлын талаар илгээсэн цахилгааны орчуулга
4	893/1161	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912- 02-07	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Лу Пян Фу руу хийсэн дайралтын талаар Хаант Орос Хятадын тайлбар, -Дорнод Хятадын төмөр замын ерөнхий даамал генерал Хорват, Хятадын Өмнөд хилийн харуулын албаны дарга генерал Матенов болон Иркутск, Байгаль мужийн зэвсэгт хүчний командлагч генерал Никитин нарын тайлбар
5	893/1162	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912- 02-08	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Монголчуудын эзэлсэн Хайлаар болон Лу Пян Фугийн байдал, Тао Тай, Ли Тиа Ао нартай уулзсаны дараа Хайлаар, Лу Пян Фу дахь Монголчууд, тэдний зэвсэг, Оросуудын нөлөө, худалдаачид, төмөр замын тээвэрлэлтийн талаар, Хятадын эрх баригчдаас Фучятин, Мачячуанко хамгаалах цэрэг илгээх тухай
6	893/1202	АНУ дахь Хаант Оросын элчин сайд Георгий Бахметов	1912- 03-23	АНУ, Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Хантингтон Вилсон	/Франц, Англи хэлээр/ -Умард Манжуур, Монгол, Өрнөд Хятад дахь Хаант Оросын ашиг сонирхлын талаар илгээсэн албан бичиг -Япон улсын санал болгосоны дагуу Хаант Орос улс Хятадыг хүлээн зөвшөөрөх эсэх талаар

					-Уг бичгийг хүлээж авсан тухай мэдэгдэл
7	893/1235	АНУ дахь Их Британийн элчин сайд Жэймс Брайс	1912-04-02	АНУ, Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Хантингтон Вилсон	1912-03-21-нд Хаант Оросын элчин сайдаас АНУ болон - -Их Британид илгээсэн албан бичгийн талаар, -Ноён Эдвард Грей урьд нь Хаант Оросын албан бичигт хариу өгөөгүй боловч одоо Хаант Оросын умард Манжуур, Монгол, Өрнөд Хятад дахь тусгай ашиг сонирхолыг зөвшөөрч буй тухай, энэ нь Хятадтай хийсэн гэрээ, хэлцэлээс гадуур буй тухай. Хавсралтаар: -Хятадын ерөнхийлөгч Хятад, Монгол, Төвдын талаар явуулж буй бодлого /Peking Daily News 1912-3-27/ -Төвдийн байдал / Peking Daily News 1912-3-26/ -Бүгд Найрамдах Хятад Улс болон Монгол, Төвдийн шарын шашин /Англи орчуулга-Le Journal de Peking 19123-27/ Монгол, Төвд, Хятад, Манжуур, Далай ламын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл
8	893/1315	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912-04-13	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Хайлард Монгол цэргүүд хяналтаа тогтоосон тухай, гарсан хохирол, дээрэм, 600 хятад иргэд баригдсан тухай. "Новая Звезда" сонины тайлбар
9	893/1425	Бээжин дэхь АНУ-н Бүрэн эрхт сайд, тусгай төлөөлөгч В.Ц. Галхаун	1912-08-21	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-АНУ-н консул Фишерийн цахилгаан -Хятадын засгийн газрын цэрэг, Монголчууд Тао Нан Фуд байлдсан тухай, -Монголчууд хотыг эзэгнэсээр байгаа, хятадууд ялагдсан тухай
10	893/1450	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул Фред.В. Фишер	1912-08-27	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Тао Нан Фу дахь Монголчуудын бослогын тухай. -Бээжин дэхь консулын төлөөлөгчийн газар Бүрэн эрхт сайд, тусгай төлөөлөгч В.Ц. Галхаунд Ерөнхий консул Фред.В. Фишерээс илгээсэн нууц шифрэлсэн мэдээний тайлал орчуулга -Уг мөргөлдөөнтэй холбогдуулан Фентэнийн цэргийн захирагч Тао Нан Фу Монголчуудад эзлэгсэнийг албан ёсоор үгүйсгэсэн тухай -1300 цэрэг, 400 хайрцаг сум, 4 пульмет 100 хайрцаг сум Ляо Юан Чоугаас Тао Нан Фуруу 22нд гарсан тухай,
11	893/1451	Фуучоугаас Фаулер Мүгдэн дэхь Америкийн консулаар дамжуулав	1912-08-23 хүлээж аваад 1912-08-27 нд дамжуулав	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Шифр - Одоогийн нөхцөл байдал -Бээжингээс их хэмжээний цэрэг илгээх тухай
12	893/1452	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул Фред.В. Фишер	1912-08-27	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-Мүгдэнгийн гадаад, дотоод нөхцөл байдал <i>Хавсралт нууцлагдсан</i>
13	893/1461	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912-08-04	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Хятадын цэрэг Монголруу хөдөлсөн тухай -Цицикараас авсан мэдээгээр Монголыг эзлэхээр 15000 цэргийн түрүүч 3000 цэрэг 08-28-ны өглөө хөдөлсөн. -Хэрэв Хунхуузууд Хайлаар болон Өргөөг эзэлвэл захирагч Чүн 200.000 таел буюу 136.000\$ -ийг

					Хунхуузын захирагчид өгөхийг санал болгосон тухай. -Монголын зарим цэрэг Шансинг орох худалдааны замд байгаа тухай - Япон-Оросын амжилтгүй хэлэлцээний үр дүн Монголруу хийх Хятадын довтолгоо болох тухай, Хан хүү Кацура болон Хан хүү Удай нарын оролцоо.
14	893/1462	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1912-08-05	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Хятадаас Монголруу хөдөлсөн цэргийн тухайнэмэлт мэдээлэл -Фунчиатенээс (Харбин) хоёр хэсэг цэрэг Бодунруу хөдөлсөн тухай -Мөн монгол 5.000 орчим цэрэг Бодунруу ирж яваа тухай -Бүх худалдааны зам хаагдсан тухай
15	893/1466	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул Фред.В. Фишер	1912-09-10	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Таонанфу дахь байлдааны тухай 9 сарын 2 нд ирүүлсэн телеграф – 40-р бригад 30-аар, 23-р девиз болон нэг бригад Кирынээс хөдөлсөн тухай, Өчигдөр ирсэн нэг суман өнөөдөр Монголруу хөдлөх тухай 9 сарын 30-нд ирүүлсэн нэмэлт телеграф – Чен тун, Та лай тинг монголчуудад эзлэгдсэн тухай Хавсралтаар: - Оросын төмөр замын компани Хятад цэрэг тээвэрлэхээс татгалзсан тухай - Чинг ан циен монголчуудад эзлэгдсэн тухай - Хятад цэргийн байрлал, 23 дивизийг дахин байгуулсан тухай, 3-р дивизийг татах тухай - Орон нутгийн компаниудтай хэлэлцэж цэргийн зардалд 1.000.000 таел гаргах болсон тухай
16	893/1481		1912-10-24	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	-10 сарын 17-нд болсон Өвөр монголын ноёд, Хятадын засгийн газар хооронд Кирийн Куан чэн цу-д болсон хуралдааны тухай -Өвөр монгол, Хятад хоёрын зөрчилийн шалтгаан, нутаг орны хил хязгаар, аймаг сумын тухай
17	893/1500	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул Фред.В. Фишер	1912-10-29	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	- Таонанфу-д байдалтай танилцахаар Мастерд болон маниас илгээгдсэн хятад түшмэлийн дэлгэрэнгүй тайлангийн орчуулга - Чанчүнд өвөр монголын хошуу ноёд, хятадын засгийн газрын төлөөлөгч, Фентиен болон Кирын мужын орон нутгын захиргааны хамтарсан хурал болох тухай - Өвөр монголын бослогыг зохицуулах комиссийн гишүүн генерал Чан Си Люан Мүгдэнд ирсэн тухай, түүнийг орон нутгийнхан хэрхэн хүлээн авч буй, Чао Эрв Цүнийг албанаас буулгах тухай
18	893/1517	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консулын орлогч Мэрл. С. Маерс	1912-11-30	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Мүгдэн дэхь улс төрийн байдал, Орос-Монголын конвенц - Орос – Монголын конвенцийн үр дүн, дүгнэлт - Уг муж дахь цэргийн байдал, байрлал - Гадаад монголын тусгаар тогтнолтой холбогдуулан авах арга хэмжээ - Кирын болон Хэйлонгчанд батлан хамгаалах

					<p>хороо байгуулж захирагчаар Чан Цо Лин томилогдсон тухай.</p> <ul style="list-style-type: none"> - Өвөр монголын Черим хорооноос амбан захирагч Чанд цэрэг ирүүлэх хүсэлт - Манжуурд тагнуул туршуултай холбогдуулан гаргасан шийдвэр - Кулун дахь Монгол-Оросын конвенцтэй холбогдуулан Ерөнхийлөгчөөс гаргасан шийдвэр
19	893/1520	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консулын орлогч Мерл. С. Маерс	1912-12-06	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын хэрэг явдал, Чан Чүн дэхь конференц /20 хуудас/</p> <ul style="list-style-type: none"> - Уг хурал болсон байдал, үүсгэл санаачлага, хурлын уур амьсгал, болсон үйл явдал <p>Хавсралт: /Хятад хэлээр болон Англи орчуулгын хамт/</p> <ul style="list-style-type: none"> - Уг хурлын гаргасан шийдвэр, явц - Монголчуудын гэрээнд тусгасан нөхцөлүүд - Уг хуралд оролцсон хүмүүсийн нэрсийн жагсаалт
20	893/1522	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консулын орлогч Мерл. С. Маерс	1912-12-14	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Бээжин дэхь АНУ-н Бүрэн эрхт сайд, тусгай төлөөлөгч В.Ц. Галхаун	<p>Мүгдэн дэхь консулын дүүрэг дэхь улс төрийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Токёо дахь Хятадын элчингээс Ерөнхийлөгч Юаньд ирүүлсэн маш нууц мэдээлэл –Токео дахь Манжийн хааныханы бүлэг Өмнөд Манжуурт халдан түрэмгийлэх бодлого явуулахгэж буй Японы тухайлсан эрх баригчидтай холбоо тогтоож уулзаж буй тухай - Энэхүү мэдээлэлтэй холбогдсон Япон Хятадын байр сууриа илэрхийлсэн байдал, энэ талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, - Манжийн хааны талыг баримтлагчид болон Японы бодлогын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл - Гадаад монголруу илгээх цэргийн оюутануудаас бүрдсэн экспедицийн тухай - Монголруу хийх дайны санхүүжилтийн талаар - Орос-Монголын конвенцид дургүйцэж Киринд 2.000 оюутан сайн дураар уг экспедицэд оролцох тухай мэдэгдэл, Кириний оршин суугчид орын бараанд хориг тавихаар заналхийлж буй тухай.
21	893/1526	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1913-01-25	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын эзэнт гүрний Гадаад Хэргийн Яамнаас илгээсэн элч</p> <ul style="list-style-type: none"> - Монголын эзэнт гүний Гадаад Яамнаас АНУ-ын Гадаад Яаманд хятад, монгол хэлээр бичсэн мэдэгдэл - Уг бичгийн англи орчуулга
22	893/1532	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консулын орлогч Мерл. С. Маерс	1913-01-20	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Бээжин дэхь АНУ-н Бүрэн эрхт сайд, тусгай төлөөлөгч В.Ц. Галхаун	<p>Мүгдэн дэхь улс төрийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн Ерөнхийлөгч Юан Ши Кай Манжуурын хилийн хамгаалалтын комиссараар Чан Пинг-Линийг сонгосон тухай, түүний намтар, явуулах арга хэмжээний тухай. - Мөн өөр хоёр комиссар болох Чан Юүхэ, Яо Ци-куан нарын намтар Бээжин дэхь Монголын хэрэг эрхлэх газар ажиллаж байсан талаар. - Монголчуудыг даруй дарж, намжаасаны төлөө

					<p>цэргийн жанжид нарт Ерөнхийлөгчийн зарлигаар шагнал өгсөн тухай.</p> <ul style="list-style-type: none"> - Монголчуудын хоёрдугаар хурал болох тухай - Өмнөд манжуурын дагуух төмөр замын хамгаалалт ихэссэн, паспортгүй солонгос болон япон иргэд Мүгдэн хотод үзэгдэх болж, их хэмжээний солонгос иргэд Манжуурт суурьших болсон тухай. - Орон нутгын компаниудтай зэвсэг, сум нийлүүлэх болон эдгээрийн санхүүжилтийн тухай
23	893/1533	Харбин дахь АНУ-н консул Листер Майнард	1913-01-15	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Хойд манжуур дахь Хунхууз нарын үймээний тухай</p> <ul style="list-style-type: none"> - Хойд манжуурын одоогийн нөхцөл байдал - Хунхууз нарын үймээний үүсэл, нөхцөл, тэдний зэвсэглэл - Хил залгаа оросууд болон хятад иргэдийн хандлага - Герман, Япон, Их Британи, Оросын консул нарын оролцоо, худалдааны компаниудын байдал <p>Хавсралт:</p> <ul style="list-style-type: none"> - Харбиний Худалдааны Танхимаас АНУ-ын Консулд илгээсэн бичгийн хуулбар
24	893/1567	Токио Япон Ларс Вилсон	1913-02-27	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монгол дахь нөхцөл байдал</p> <ul style="list-style-type: none"> - Токиогийн "Токуо Nichi Nichi Shimbun" сонины 02-14 ны дугаарт хэвлэгдсэн нийтлэлийн орчуулга - Уг нийтлэлд Танака Гадаад Монгол, Өвөр Монголын байдал тэдний хандлага, Богд хаанаас Японы элчинд илгээсэн бичгийн тухай зэргийг өгүүлсэн байна.
25	893/1612	Хятад, Бээжин дэхь АНУ-ын 1-р нарийн бичгийн дарга Э. Виллиамс	1913-03-18	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Хятадын улс төрийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Удирдах хороо, зөвлөл - Санхүү - Монгол гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэж байна.
26	893/1700	Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг хамаарагч Э. Виллиамс	1913-05-16	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Доктор Сүн Ят Сен, Генерал.Хуан Шинг болон Чен Чимэй нар Бээжингийн засгийн газрын эсрэг босох гэж буй үеийн Хятадын улс төрийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Хятадын дотоод байдал, улс төрийн дэлгэрэнгүй тайлан - Монголд цэрэг хуралдаж байгаа, Өвөр монгол, Хөх нуур, Ховдыг Гадаад монголд нийлүүлэх тухай мэдээ - Гадаад монголын өмнөд хилийн талаархи санал - Манжийн төлөөлөгч нар монголтой хамтран манж улс байгуулах санал - Далай лам монголд туркестаныг нэгтгэхэд туслах гэсэн мэдээ гэх мэт

					Хавсралт: - Ноён Уалдерийн меморандум
27	893/2313	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул П. С. Хэйнцлэман	1915-08-27	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Бээжин дэхь АНУ-н Хэргийг хамаарагч Ж. В. Ав Макмиррей	Дорнод монголруу цагаачилж буй хятадуудын талаар - Тухайлсан мужаас хятад иргэдийг- түрүүч болгож 800 иргэнийг өвөр монголруу цагаачлуулахыг Ерөнхийлөгчийн удирдамжын дагуу Нийгэмийн сайдаас Дотоод хэргийн сайдад зөвлөмж болгосон тухай, Франц герман иргэдийг ч, мөн уг бүсэд хөрөнгө оруулалт хийх тухай - Умард, өрнөд манжуур болон дорнод монгол нутгын ач холбогдол, цагаачлуулах шалтгаан - Уг бүс дэхь Японы ашиг сонирхол
28	893/				Шантун болон Монголын дээрэмчидтэй Япон сүлбэлдэж буй тухай - "Peking Gazette" сонины 1917 оны 4 сарын 6-ны сонины хайчилбар Хөлөнбуйр орчим монголын эзэн хааны угсаа хэмээн өөрсдийгөө нэрлэсэн дээрэмчидийн тухай
29	893/3013	Мүгдэн дэхь АНУ-н ерөнхий консул Томас Саммонс	1919-02-28	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Бээжин дэхь АНУ-н сайд Пол. С. Рэйнсч	Улс төрийн холбоо – Монголын ирээдүй North China Daily News (Их Британийн) сонинд гарсан нийтлэлд монголын ирээдүйг дүрсэлсэн мэдээ - Монгол Их гүрэн Хятад болон Оросын дундах буфер гэдгээ ойлгож байна. Үүнд Япон яаж оролцох талаар
30	893/3225	Рой Андерсон	1919-10-14	АНУ-ын Төрийн Яамны Алс Дорнодыг хариуцсан хэлтэс	Өмнөд Хятадын байдал - Япон Манжуур болон Монголыг эдийн засгаас илүү батлан хамгаалах зорилгоор сонирхож буй талаар - Хятадын Анфу клуб болон Өмнөд цэргийн эвсэлийн тухай
31	893/3429	Хятад, Харбин Грей Стивонс	1920-06-31	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Шифрэлсэн мэдээ - Бээжин дэхь Японы элчин Тюан Су-г монгол явуулж Хятадын нөлөөнөөс гаргахыг ятгуулахаар болсон тухай, энэ үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай амлалт
32	893/3555	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1920-09-09	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Европоос буцаж явсан АНУ-ын цэргийн аташшегаар дамжуулан АНУ-ын ард түмэнд Монгол улсын ноёд түшмэдээс Богд хааны тамгаар баталгаажуулсан өргөх бичиг. Хавсралт: - Уг бичгийн англи орчуулга
33	893/3570	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1920-09-04	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Монголын автономыг цуцалсан тухай Хятадын Гадаад Яамнаас Оросын Консулд илгээсэн меморандумын орчуулга

34	893/	Хятад, Кантон, Бээжин Грин Крейн	1920- 10-19	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Хятадын засгийн газар Гадаад монголруу цэрэг илгээх тухай
35	893/3634	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1920- 10-28	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Гадаад монголын нөхцөл байдалын тухай Хятадын Гадаад Хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгч В. В. Иенээс Америкийн сайд Р. Крейнд илгээсэн 3 нот бичиг (орчуулга) <ul style="list-style-type: none"> - (1920-10-05 нд) Гадаад монголын автономии цуцлагдсантай холбогдуулан уурхайн олборлолтын гэрээг Хятадын Төв засгийн газартай хийх тухай - (1920-10-14) Гадаад монгол дахь үймээнтэй холбогдуулан монголд зорчих иргэд, бусад зүйлсийн талаар - (1920-10-13) Монгол дахь АНУ-ын компанийн талаар АНУ-ын консулаас ирүүлсэн Нотны хариу
36	893/3668	Хятад, Тианцин АНУ-ын Ерөнхий консул Стюарт. Ж. Фуллер	1920- 11-13	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	---
37	893/3668	АНУ, Вашингтон, Төрийн Яам	1220- 12-28	Хятад, Бээжин Амлегашион	Шифр- Өргөө дэхь өнөөгийн байдалыг мэдээлэх хүсэлт
38	893/3671	Хятад, Тианцин АНУ-ын Ерөнхий консул Стюарт. Ж. Фуллер Америкийн Тианциен дахь Худ-ы Танхим Ротиер. Л. Эванс	1920- 11-22	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Бээжин дэхь Америкийн сайд Р. Крейнд	Монголын Өргөө дахь АНУ-ын хөрөнгийг хамгаалах хүсэлт <ul style="list-style-type: none"> - Тианцин дахь Худалдааны Танхимаас Вашингтон дахь Худалдааны Танхимд илгээсэн захидал, түүний хариу.
39	893/3673	Хятад, Тианцин АНУ-ын Ерөнхий консул Стюарт. Ж. Фуллер	1920- 11-24	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Монгол дахь үймээний тухай <ul style="list-style-type: none"> - Peking & Tientsin Times сонины 1920-11-23 ны сонины нийтлэл “Монголд Хятадууд гадуурхагдаж байна”
40	893/3683	Хятад, Тианцин АНУ-ын Ерөнхий консул Стюарт. Ж. Фуллер	1920- 12-04	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Монгол дахь үймээний тухай <ul style="list-style-type: none"> - Андерсон, Маер Компанийн жин дээрэмдүүлсэн тухай, дээрэмдүүлсэн газар, үнэ - Дээрэмдэлтийн тухай яаралтай цахилгаан
41	893/3900	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1920- 11-29	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Хятад дахь Quaranty Trust Company-ийн төлөөлөгч ноён Мерле Уолкер Өргөө хот дахь нөхцөл байдалын тухай тайлан <ul style="list-style-type: none"> - Нутгийн байдал - Хүмүүсийнх нь зан араншин - Одоогийн нөхцөл байдал - Зам тээвэрийн нөхцөл байдал - Мал аж ахуй - Түүхий эд арьс, үс - Одоогийн газар тариалангийн байдал

					<ul style="list-style-type: none"> - Банк санхүү - Төмөр зам
42	893/3803	Хятад Харбин Грин Жонсон	1921- 03-23	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Бээжин дэхь Японы элчин Японы Гадаад Хэргийн сайдад илгээсэн хоёр удаагийн цахилгаан</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Хятадыг цаашид дагахгүй, орост туслах тухай, японы холбооны тухай Хутагт Хятадын засгийн газарт мэдэгдсэн мэдэгдэл - Хятадын команд, Алс Дорнодын Бүгд Найрамдах Улс хоорондоо Монголчуудын эсрэг тохиролцоонд хүрсэн тухай
43	893/3827	Хятад, Харбин Грей Женкинс	1921- 04-15	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын цэргийн нэг хэсэг Хайлар, Манжуур өртөөний ойролцоо үйл ажиллагаа явуулж буй тухай. Хятадын засгийн газар анхааруулж цэрэг илгээх тухай</p>
44	893/3906	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1921- 05-06	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Гадаад монголын талаар, Тианцинд Ерөнхий сайд Чин Юн-пэн, генерал Чан Цо-лин, генерал Цао Кун, генерал Ван Чан-юан нарын уулзалтын талаар сонины хайчилбар</p> <ul style="list-style-type: none"> - "Peking Leader" сонины 1921-04-13 ны дугаарт гарсан "Цэргийн удирдагчидын хурал удахгүй болно" нийтлэл (Монголыг сэргээх төлөвлөгөөний тухай) - "Peking Leader" сонины 1921-04-17 ны дугаарт гарсан "Тианцинд Чан Цо-лин Цао Кунтэй З/Г кабинетын талаар хэлэлцэнэ" нийтлэл (Хэлэлцэх зүйлд Гадаад Монголын тухай) - "Peking Leader" сонины 1921-04-19 ны дугаарт гарсан "Чан Цо-лин, Цао Кун нар кабинетэд туслахыг зөвшөөрөв" нийтлэл (Өргөөрүү хийх цэргийн аяны санхүүжилт) - "Peking Leader" сонины 1921-04-20 ны дугаарт гарсан "Кабинетын гишүүд Тианциний хуралд санаа зовниж байна" нийтлэл (Квантунруу дайн хийхийн оронд Өргөөрүү, Хутагтыг буулгах тухай) - "Peking Leader" сонины 1921-04-21 ны дугаарт гарсан "Чан Цо-лин, Цао Кун нар Ван Чан-юаны ирэхийг хүлээж байна" нийтлэл (Кантоноос Монгол хүртэл хэлэлцэнэ) - "Peking Leader" сонины 1921-04-22 ны дугаарт гарсан "Засгийн газрын амжилт Дайны 3 жанжинаас шалтгаална" нийтлэл (Богдын энхийн санал, Өргөө дэхь Унгерний оролцоо) - "Peking Leader" сонины 1921-04-27 ны дугаарт гарсан "Хурлын үр дүнгийн талаар 3 жанжин дуугүй байна" нийтлэл - "Peking Leader" сонины 1921-04-28 ны дугаарт гарсан "Тианциний хурал Бээжинг харанхуйд нөмрүүлсээр" нийтлэл (Чита, Иркутскийн байдал, Буфер болж чадах уу) - "Peking & Tientsin Times" сонины 1921-04-18 ны дугаарт гарсан "Чан Цо-лин Тианцинд" нийтлэл (Ройтерийн агентаар – Хятадын дотоод асуудал, Гадаад Монголын талаар

					<p>нэгдсэн ойлголттой болох талаар)</p> <ul style="list-style-type: none"> - “Peking & Tientsin Times” сонины 1921-04-18 ны дугаарт гарсан “<i>Туанциний Хурал</i>” нийтлэл (Гадаад Монголын талаар 3 генерал хэлэлцэх нь тодорхой) - “Peking & Tientsin Times” сонины 1921-04-22 ны дугаарт гарсан “<i>Цэргийн Бодлого</i>” нийтлэл (Монголд хийх даяны тухай дэлгэрэнгүй) - “Peking & Tientsin Times” сонины 1921-04-27 ны дугаарт гарсан “<i>Умард дахь 3-ын засаглал</i>” нийтлэл (Хятадын гадаад, дотоод байдалын талаар)
45	893/3907	Хятад, Бээжин АНУ-ын Сайдын орлогч Арт Руддок	1921-05-09	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>1921 оны 5 сарын 1-нд дуусч буй долоо хоногын улс төр, цэрэг дайны тайлан</p> <p>Улс Төр:</p> <ul style="list-style-type: none"> - Умардын улс төр - Монгол - Манжуур, Сибир - Орос-Хятадын харилцаа - Хятад-Британын харилцаа <p>Цэргийн байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Сибир - Монгол - Манжуур - Умард Хятад - Төв Хятад - Өмнөд Хятад - Баруун Өмнөд Хятад - Агаарынтээвэр нисэх хүчин
46	893/3958	Хятад, Хаалган АНУ-ын Дэд Консулын үүрэг гүйцэтгэгч Самуэл Сокобин	1921-06-23	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын удирдагчид Хаалган хотоос Мүгдэнрүү Чан Цо-линий удирдлаганд болох хуралд оролцохоор хөдөлсөн тухай</p> <p>Монголруу хийж буй хятадын дайн, цэргүүд</p> <p>Хаалганы байдал</p> <p>Өргөө дэхь Барон Унгерний довтолгоо</p>
47	893/3987	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-07-12	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Манжуурын улс төр, эдийн засаг, худалдааны талаархи орон нутгын сониноос цуглуулсан мэдээллүүд</p> <ul style="list-style-type: none"> - Яанзе хөндийн тухай - Квантунаас гаргасан Алтан баталгааны тухай - Квантуны засгийн газар - Хунчуны асуудал - Манжуур дахь Японы үйлдвэрлэл - Чанцо лин болон Окура нар хамтрах тухай - Манжуурт Америк худалдаачин америк бараа худалдах тухай - Чан цо-лин хятадын генералуудыг Барон Унгерн, Семёновт мэдээлэл дамжуулсан хэргээр баривчлав - Лишиг монголчууд дайраагүй тухай - Монгол хан нарын хандлага

					<ul style="list-style-type: none"> - Монголыг тохинуулах хорооны тухай - Чан цо лийн монголруу хийж буй дайралтын тухай - Банкуудын үлдэгдэл
48	893/3988	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-07-07	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг Түр Хамаарагч (Charge d'Affaires) Арт. Б. Руддок	Мүгдэн дэхь улс төрийн байдал Манжуурын байдал Монголыг тохинуулах хороо Чан Цо Лийн үйл ажиллагаа
49	893/3989	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-07-11	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг Түр Хамаарагч (Charge d'Affaires) Арт. Б. Руддок	Монголд хийх Цэргийн ажиллагааны талаархи мэдээлэл <ul style="list-style-type: none"> - Монголд явуулах цэргийн ажиллагааны талаархи дэлгэрэнгүй тайлан - Ажиллагаанд хамрагдах цэрэг, зэвсэг, анги нэгтгэл - Санхүүжилт
50	893/3991	Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг Түр Хамаарагч (Charge d'Affaires) Арт. Б. Руддок	1921-07-24	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Хятад дахь улс төрийн мэдэгдэл, тайлангууд Хавсралтаар: <ul style="list-style-type: none"> - 1921 оны 5 сарын 29 нд дууссан долоо хоногийн улс төрийн илтгэл - 1921 оны 5 сарын улс төрийн утсан илтгэл - 6 сарын 5-нд дууссан долоо хоногийн улс төрийн илтгэл - 5 сарын 23 –аас 6 сарын 5 ны хураангуй илтгэл
51	893/4005	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-07-18	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг Түр Хамаарагч (Charge d'Affaires) Арт. Б. Руддок	Монголд явуулах цэргийн ажиллагааны тухай <ul style="list-style-type: none"> - Монголд явуулах цэргийн ажиллагааны бэлтгэл хангагдаж буй тухай - Сум хэрэгсэл хүлээж авсан тухай - Чан Цо лин Монгол хөдлөхөөр шийдсэн болон Алс Дорнодын Бүгд Найрамдах Улс хамтрах болсон тухай
52	893/4006	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-07-20	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	Мүгдэн дэхь улс төрийн байдалын талаархи илтгэл <ul style="list-style-type: none"> - 6 сарын 19- ээс 26-ны хоорондох цэрэг, улс төрийн илтгэл - Маршал Чан Цо-Лийн Монгол явах нь цуцлагдсан тухай
53	893/4017	Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921-08-01	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга Хятад, Бээжин дэхь АНУ-ын Хэргийг Түр Хамаарагч (Charge d'Affaires) Арт. Б. Руддок	Монголд явуулах цэргийн ажиллагааг цуцалсан тухай <ul style="list-style-type: none"> - Уг ажиллагааг цуцлах болсон шалтгаан - Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын нөлөө , гэрээ - Төв Засгийн газарт Монголыг Гадаад, Дотоод гэж салгаж бодлогын зохицуулалт хийх саналын тухай - Маршал Чаны үзэл бодол - Өргөө дэхь байдал
54	893/4026	Хятад, Мүгдэн АНУ-ын	1921-08-09	АНУ, Вашингтон, Төрийн нарийн	Манжуур, монголын улс төр эдийн засгийн байдал /7сарын 25 –аас 8 сарын 9 –ны хоорондох хэвлэл, тусгай

		Ерөнхий консул Алберт. В. Понтиус		бичгийн дарга	<p>агентуудаас авсан мэдээлэлүүд/</p> <ul style="list-style-type: none"> - Өргөөг буцаан байгуулах тухай, - Өргөө хот дахь Читийн цэргүүд - Улаанууд Өргөөг Хятад буцаан өгнө гэж найдаж буй тухай - Юүрины томилолт <p>Хятад-Монголын харилцаа</p> <p>Орос- Монголын харилцаа</p> <p>Дорнод Сибирийн тухай</p> <p>Хятад-Японы харилцаа</p> <p>Монгол</p> <p>Оросын харилцаа</p>
55	893/4133	Хятад, Хаалган АНУ-ын Дэд Консулын үүрэг гүйцэтгэгч Самуэл Сокобин	1921-11-23	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын засгийн газрын талаархи мэдэгдэл Өргөө болон Монгол дахь байдал, улс төр, оросын нөлөө, худалдаа</p> <p>Хавсралт:</p> <ul style="list-style-type: none"> - Бүх Монголын Ардын цэргийн Зөвлөлын Хэлтэсийн Газраас, 16-р тушаал (1921-08-13 Орос монгол бичгээр) - Объявление /Начадмотдела Нарамандахт/ - Бүх Монголын Ардын цэргийн Зөвлөлын Хэлтэсийн Газраас, 18-р тушаал (1921-08-13 Орос хэлээр) - Ухуулга бичиг /Шар хаданд сургуулийн буудлага хийх тухай/ 8-26нд - Бүх Монголын Ардын цэргийн Зөвлөлын Хэлтэсийн Газраас, 25-р тушаал (1921-08-27 Орос хэлээр) - Тунхаг зарлал //Орос, монгол хэлээр - Обязательное постановление - Андерсон Мээр компани иргэн Котоввд Ардын Хувьсгалт Засгийн Газраас /Орос, Англи орчуулгын хамт/ - Сонины хайчилбар /англиар/ Москвагаас харахад /Монголын талаар/ Дээрхи 10 материалын тайлбар англи хэлээр
56	893/4136	Хятад, Хаалган АНУ-ын Дэд Консулын үүрэг гүйцэтгэгч Самуэл Сокобин	1921-10-10	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын Өргөө хот, нөхцөл байдал</p> <p>Монголын улс төр, эдийн засаг, цэрэг зэвсэг гадаад дотоод харилцааны талаархи маш дэлгэрэнгүй тайлан /НИЙТ 35 ХУУДАС/</p> <ul style="list-style-type: none"> - Шарын Шашны тэргүүн Хутагтаас АНУ-н Консулд бичсэн бичгийн англи орчуулга
57	893/4136	АНУ-н Төрийн Яам Нарийн бичгийн Алба Вилбур. Ж. Гэйр	1921-12-17	Хятад, Хаалган АНУ-ын Консул Самуэл Сокобин	<p>Монголын талаархи мэдээлэлийг цаашид сонирхон мэдээлж байх хүсэлт</p> <p>Ялангуяа Монголын Хятадтай, ЗХУ-тай, Алс Дорнодын Бүгд Найрамдах Улстай харилцах харилцааг ажиглан харж байхыг...</p>
58	893/4141	Хятад, Хаалган АНУ-ын Дэд Консулын үүрэг гүйцэтгэгч Самуэл Сокобин	1921-10-28	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монгол дахь хувьсгалыг эсэргүүцэгч нарын тухай</p> <ul style="list-style-type: none"> - Өргөө хотод Андерсон Мээр компанийн байр болон Өргөө дэхь салбарын менежер Шведийн иргэн Ф. А. Ларсоны гэрт нэгжлэгэ хийсэн тухай, үүний шалтгаан - The Northern China Star сонинд гарсан Улаанууд Хутагттай муудалцсан нь гэсэн нийтлэл - Монголын байдалын талаар гарсан хэд хэдэн

					нийтлэл -
59		Хятад, Мүгдэн АНУ-ын Ерөнхий консул Алберт. В. Понтиус	1921- 12-12	Хятад, Бээжин дэхь АНУ-ын сайд Якоб Геулд Шурман	Мүгдэн дэхь Консулын дүүрэг дэхь улс төр эдийн засгийн байдал
60	893/4215	Хятад, Хаалган АНУ-ын Консул Самуэл Сокобин	1921- 12-23	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Өргөө дэхь АНУ-ын бизнесийн сонирхол</p> <ul style="list-style-type: none"> - АНУ-ын бизнесийнашиг сонрхолын үүднээс Өргөө хоруу хийх аялалын тухай, зөвшөөрөл хүсэх тухай - Ларсоны санал, түүний байр суурь <p>Өргөө дэхь Андерсон Мээр компанийн Эжил Кюли Хансенаас Хаалганд буй ноён Ф. А. Ларсонд ирүүлсэн бичиг</p> <ul style="list-style-type: none"> - Монголын Ерөнхий сайд Бодоо, болон Англиар сайн ярьдаг Дамба зэрэг албаны хүмүүс ирж Ларсоныг Өргөөд ирэхийг хүсч, компани үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулж болох тухай, оросын мөнгөн зоосоор үйлчилэхгүй байх тухай, АНУ-ын Консулыг урьж буй тухай, АНУ-Монголын хооронд худалдааны гэрээ хийх тухай бичсэн <p>Ларсоноос Консул Сокобинд дээрхи аялалтай холбогдуулан бичсэн захидал</p> <p>Консул Сокобиноос Ларсонд Өргөөрүү хийх аялалын талаар, Төрийн Яамны зөвшөөрөл хүлээж буй тухай, Ларсонтой өөртэй нь хамт явж чадахгүй шалтгааны тайлбар</p>
61	893/4221	АНУ Вашингтон хот, Букинхам зочид буудал А. Т. Осендовски	1921- 11-28		<p style="text-align: center;">Монголын талаархи А. Ф. Осендовскийн нууц Меморандум</p> <p style="text-align: center;">/Орос гар бичмэл, Англи орчуулга/</p>
62	893/4347	Хятад, Хаалган АНУ-ын Консул Самуэл Сокобин	1922- 03-28	АНУ, Вашингтон, Төрийн нарийн бичгийн дарга	<p>Монголын Өргөө хотын байдал АНУ-ын консул Самуэл Сокобин 1922 оны 1 сараас 2 сард Өргөө хотод байсан дэлгэрэнгүй тайлан. Нийт 57 хуудас үүнээс 45 хуудас мэдээ тайлан, 22 хуудас хавсралт тайлан</p> <p>Агуулга: Улс төрийн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Монголын асуудал дээр монголын оролцоо А/ Залуу Ардын намын хүчирхэгжилт Б/ Ерөнхий сайдын огцруулалт В/ Ерөнхий сайдад Да Ламыг залах тухай - Монголын асуудал дээр Оросын оролцоо А/ Оросын цэргийг Монголд байлгаж буйн шалтгаан Б/ Орос-Монголын шинэ гэрээ В/ Оросуудын хүнсний хангамж Г/ Монгол дахь Болшевикийн ятгалга Д/ монгол дахь Оросын нөлөөний дэлгэрэлт - Орос-Хятадын харилцаа А/ Өргөө дэхь Хятадын төлөөлөгч Б/ Телеграфийн зохицуулалт - Эдийн засгийн байдал А/ Монгол Хятад Оросын худалдаа Б/ Засгийн газрын бодлого В/ Уурхайн зөвшөөрөл Г/ Америкийн нөлөө Д/ Телеграфийн шугамын засвар <p>Юмны үнэ ханш, хэлсэн үг, гэрээ гэх мэт маш олон сонирхолтой баримтууд байна.</p>

					Сонины хайчилбар
--	--	--	--	--	------------------